



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 29 өдөр

Дугаар А/797

Ховд

Архивчдын өдрийг тэмдэглэн  
өнгөрүүлэх тухай

Засгийн газрын 2019 оны 369 дүгээр тогтоолоор батлагдсан "Түүхэн үйл явдлыг ой, тэмдэглэлт өдөр"-ийн 1 дүгээр хавсралт "Түүхэн үйл явдлыг ой, тэмдэглэлт өдрийн жагсаалт" -ын 2 дугаар зүйлийн 2.50, 2 дугаар хавсралт "Түүхэн үйл явдлыг ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2.4, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн хэмжээнд 2019 онд зохион байгуулах нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөө"-ний 4 дүгээр бүлгийн 4.1, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Архивчдын өдрийг 2019 оны 12 дугаар сарын 4-6-ны өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд зохион байгуулагдах сургалт, семинар, эрдэм шинжилгээний бага хурал, спортын арга хэмжээний зардалд 1.500.000 төгрөгийг зарцуулсугай.


2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 1.500.000 төгрөг /Нэг сая таван зуун мянган /-ийг "Тайван-амгалан-Ховдчууд" хөтөлбөрийн зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Д.Энхболд, аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



Аймгийн Засаг даргын 2019 оны  
11 дүгээр сарын 29-ний өдрийн  
А/797 дугаар захирамжийн хавсралт



“АРХИВЧДЫН ӨДӨР”-ИЙГ ТЭМДЭГЛЭН  
ӨНГӨРҮҮЛЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Хийгдэх ажил	Гарах зардлын нэр төрөл	Нэг бүрийн үнэ	Нийт зардал
1	Сургалт, семинар	2 удаа цайны завсарлага	57 х 5000	285.000
2	Тэмцээн	Өргөмжлөл Медаль	3 х 10000 18 х 5000	30.000 90.000
3	Эрдэм шинжилгээний бага хурал	Өргөмжлөл Мөнгөн шагнал	3 х 10000 45000	30.000 45.000
4	Хоол	57 хүн	17895	1.020.000
	Нийт дүн			1.500.000